ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цагаанхайрхан сумын Ерөнхий боловролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ЗАА-202/139/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улиастай сум<br>2025 он | Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа<br>Утас: 99993365<br>Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn<br>Аудитын менежер: Х.Болдбаатар<br>Утас: 99105506<br>Цахим хаяг: Boldbaatarkh@audit.gov.mn<br>Хаан соёмбо аудит ХХК -гэрээт аудитор: Б.Цэрэндэжид<br>Утас: 99812811<br>Цахим хаяг: tserendejid1109@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**


1. Хараат бус аудиторын дүгнэлт 3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл 4
   2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан 4
   2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан 4
   2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан 5
   2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан 6
   2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.......8
   3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа 8
   3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин 10
   3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал 10
   3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт 11
4. Аудитын тайлан.......13
   4.1 Ерөнхий зүйл .......13
   4.2 Материаллаг байдал .......14
   4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.......14
   4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .......14
   4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .......15
   4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .......16
5. Аудитын илрүүлэлт .......16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
[illegible]

ЦАГААНХАЙРХАН СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Г.МЯГМАРСҮРЭН-Д

2025.02.21 -ны № 212

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цагаанхайрхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цагаанхайрхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Цагаанхайрхан сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 65 ажил төлөвлөж, хэрэгжилт 93 хувьтай дүгнэгджээ. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 оноос спорт заалны барилгын ажил эхэлсэн бөгөөд гүйцэтгэгчээр "Тэмүүлэх гал" ХХК ажиллаж, барилгын ажил тодорхой бус шалтгааны улмаас одоог хүртэл ашиглалтад ороогүй байна

Мөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 240 хүүхдийн хичээлийн байр баригдаж эхэлсэн бөгөөд гүйцэтгэгчээр "РСТ" ХХК ажиллаж байна. Боловсрол шинжлэх ухааны яамны төсвийн бодлогын хүрээний дагуу цахим анги кабинет байгуулах зорилгоор хэрэгжүүлж буй үйл ажиллагаанууд, утасгүй интернэтийн тоног төхөөрөмжийг нэвтрүүлэн ажилласан байна.

**Аудитын гол асуудал**

Цагаанхайрхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 188 нэр төрлийн 113,181.1 мянган төгрөгийн үлдэх өртөггүй хөрөнгийг дахин үнэлж, ашиглах хугацааг сунгаагүй, 1,453.0 мянган төгрөгийн зардлыг эдийн засгийн ангиллаар



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

зарцуулаагүй байна.

**Бусад асуудлын хэсэг**

Цагаанхайрхан сумын Ерөнхий боловсролын сургууль нь төсвийн хөрөнгөөр 119,337 7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч, Боловсролын ерөнхий газрын хөрөнгө оруулалтаар 11,443.1 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, Олон улсын энэрлийн байгууллагаас 8,000.0 мянган төгрөгийн зөөврийн компьютер, сумын 100-н жилийн ойн хүрээнд ахмад ажилчдын хандиваар 3,550.0 мянган төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж, 4,657.5 мянган төгрөгийн ном, 6,496.0 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө нийлүүлэгдсэнийг данс бүртгэлд тусгасан байна.

Тус сургууль нь Цагаанхайрхан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 22 дугаар тогтоолоор 16,771 3 мянган төгрөгийн тавилга эд хогшил, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2024 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн А/29 дугаар захирамжаар 44,722.4 мянган төгрөгийн сургуулийн барилга, 1,842.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 12,877 1 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 521 7 төгрөгийн программ хангамжийг акталж данс бүртгэлээс хассан байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-ҮНДРАА

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31* *\/төгрөгөөр/*

# САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Байгууллагын нэр: Цагаанхайрхан Ерөнхий боловролын сургууль

Тайлант хугацаа: 2024.12.31

| Данс | Балансын зүйл | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 94,405,552.50 | 220,042,893.10 |
| 31 | МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ | 18,524,163.45 | 158,761,989.11 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 18,524,163.45 | 158,761,989.11 |
| 3121 | Төгрөг | 18,524,163.45 | 158,761,989.11 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 18,524,163.45 | 158,761,989.11 |
| 31215 | Нэмэлт санхүүжилтийн харилцах | (0.00) | (0.00) |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 75,881,389.05 | 61,280,903.99 |
| 351 | Түүхий эд материал | 5,424,621.60 | 4,651,301.60 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 4,621,121.60 | 3,847,801.60 |
| 35130 | Эм боох материал | 803,500.00 | 803,500.00 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 6,387,202.00 | 8,470,041.15 |
| 354 | Хангамжийн материал | 63,699,565.45 | 47,889,561.24 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,473,792.40 | 2,594,744.40 |
| 35420 | Аж ахуйн материал | 14,356,444.00 | 9,370,974.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 2,204,500.00 | 2,220,600.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 9,569,920.00 | 250,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 7,742,971.00 | 7,796,363.99 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 27,351,938.05 | 25,656,878.85 |
| 35600 | Мал, амьтад | 370,000.00 | 270,000.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 781,515,472.02 | 831,712,279.08 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 781,515,472.02 | 831,712,279.08 |
| 392 | Биет хөрөнгө | 745,635,972.02 | 789,666,779.08 |
| 39201 | Барилга, байгууламж | 465,143,788.00 | 375,698,934.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (194,054,404.60) | (123,102,040.92) |
| 39203 | Авто тээврийн хэрэгсэл | 13,842,000.00 | 12,000,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (9,842,000.16) | (10,000,000.20) |
| 39205 | Машин, тоног төхөөрөмж | 110,131,582.85 | 238,585,269.85 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (73,576,408.75) | (91,657,696.10) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 66,558,138.00 | 62,282,668.33 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (38,215,139.53) | (37,704,099.52) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 471,995,073.50 | 468,617,929.50 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (87,333,327.39) | (128,205,645.26) |
| 39217 | Номын фонд | 20,986,670.10 | 23,151,459.40 |

| | | | |
|---|---|---|---|
| 393 | Биет бус хөрөнгө | 35,879,500.00 | 42,045,500.00 |
| 39301 | Програм хангамж | 2,551,700.00 | 2,030,000.00 |
| 39302 | Хасагдуулга | (2,084,200.00) | (1,892,500.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 35,412,000.00 | 41,908,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 875,921,024.52 | 1,051,755,172.18 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН | 1,549,950.00 | 79,618,248.00 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 1,549,950.00 | 79,618,248.00 |
| 413 | Өглөг | 1,549,950.00 | 79,618,248.00 |
| 4136 | Бусад өглөг | 1,549,950.00 | 79,618,248.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 1,549,950.00 | 79,618,248.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН | 874,371,074.52 | 972,136,924.18 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 874,371,074.52 | 972,136,924.18 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан | 278,923,016.50 | 278,923,016.50 |
| 51101 | Өмч: -Төрийн өмч | 278,923,016.50 | 278,923,016.50 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 52,764,822.02 | 239,975,525.68 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 52,764,822.02 | 142,209,676.02 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 97,765,849.66 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 542,683,236.00 | 453,238,382.00 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН | 875,921,024.52 | 1,051,755,172.18 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31* */төгрөгөөр/*

Байгууллагын нэр: Цагаанхайрхан Ерөнхий боловролын сургууль

Тайлант хугацаа: 2024.12.31

**САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

| данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 862,607,832.03 | 1,320,631,997.90 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 14,468,832.03 | 35,946,607.90 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 14,468,832.03 | 35,946,607.90 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 14,468,832.03 | 35,946,607.90 |
| 1200044 | Бараа материалын үнэгүй орлого | 2,201,389.60 | 1,800,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 12,267,442.43 | 34,146,607.90 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 848,139,000.00 | 1,284,685,390.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 768,620,800.00 | 1,177,697,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 768,620,800.00 | 1,177,697,400.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 1,008,600.00 | 3,202,190.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи | 338,600.00 | 2,646,690.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 670,000.00 | 555,500.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 78,509,600.00 | 103,785,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 78,509,600.00 | 103,785,800.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II) | 929,167,647.76 | 1,220,373,419.64 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 929,167,647.76 | 1,220,373,419.64 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 910,723,419.20 | 1,202,231,246.79 |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 615,613,915.00 | 830,370,548.00 |
| 210101 | Цалин | 409,754,221.00 | 489,986,277.00 |
| 210102 | Нэмэгдэл цалин | 179,916,444.00 | 300,769,681.00 |
| 210104 | Урамшуулал | 25,943,250.00 | 39,614,590.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 77,554,400.00 | 103,180,452.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 52,736,800.00 | 74,567,200.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 6,204,200.00 | 8,409,300.00 |
| 210203 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 4,963,700.00 | 1,842,800.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 1,241,000.00 | 1,842,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 12,408,700.00 | 16,518,352.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 73,672,658.44 | 94,322,250.00 |
| 210301 | Гэрэл цахилгааны зардал | 7,901,028.44 | 9,244,754.28 |
| 210302 | Түлш, халаалтын зардал | 64,093,780.00 | 84,022,652.00 |
| 210303 | Цэвэр, бохир усны зардал | 1,677,850.00 | 1,054,843.72 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | - | 4,864,270.00 |
| 210408 | Бараа материал актасны зардал | - | 4,864,270.00 |
| 2105 | Нормативт зардал | 22,070,645.00 | 23,529,897.01 |
| 210502 | Хоол | 22,070,645.00 | 23,529,897.01 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 3,277,630.00 | 18,767,370.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,277,630.00 | 18,767,370.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 2,207,100.00 | 7,785,622.06 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 338,600.00 | 555,500.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210806 | Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс | 1,868,500.00 | 7,230,122.06 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 116,327,070.76 | 119,410,837.72 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 14,640,918.10 | 16,613,312.48 |
| 210902 | Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал | 2,646,953.00 | 2,002,748.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 99,039,199.66 | 100,794,777.24 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 18,444,228.56 | 18,142,172.85 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 18,440,487.00 | 18,142,172.85 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 18,440,487.00 | 18,142,172.85 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 3,741.56 | - |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,741.56 | - |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II) | (66,559,815.73) | 100,258,578.26 |
| 145 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV) | 40,000.00 | - |
| 145002 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз | 40,000.00 | - |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V) | - | 2,492,728.60 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | - | 2,492,728.60 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V) | 40,000.00 | (2,492,728.60) |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI) | (66,519,815.73) | 97,765,849.66 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31* *\/төгрөгөөр/*

Байгууллагын нэр: Цагаанхайрхан Ерөнхий боловролын сургууль

Тайлант хугацаа: 2024.12.31

### МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 850,399,000.00 | 1,284,685,390.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 850,399,000.00 | 1,284,685,390.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 768,620,800.00 | 1,177,697,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 768,620,800.00 | 1,177,697,400.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 3,268,600.00 | 3,202,190.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи | 338,600.00 | 2,646,690.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 2,930,000.00 | 555,500.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 78,509,600.00 | 103,785,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 78,509,600.00 | 103,785,800.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II) | 826,910,659.50 | 1,104,728,107.34 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 826,910,659.50 | 1,104,728,107.34 |
| 210 | БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 811,828,788.94 | 1,084,503,095.34 |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 615,613,915.00 | 830,370,548.00 |
| 210101 | Үндсэн цалин | 409,754,221.00 | 489,986,277.00 |
| 210102 | Нэмэгдэл | 179,916,444.00 | 300,769,681.00 |
| 210104 | Үр дүнгийн урамшуулал | 25,943,250.00 | 39,614,590.00 |
| 2102 | Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимттэл | 77,554,400.00 | 103,180,452.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 52,736,800.00 | 74,567,200.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 6,204,200.00 | 8,409,300.00 |
| 210203 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 4,963,700.00 | 1,842,800.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 1,241,000.00 | 1,842,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 12,408,700.00 | 16,518,352.00 |
| 2103 | Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал | 74,506,158.44 | 94,338,350.00 |
| 210301 | Гэрэл цахилгааны зардал | 7,901,028.44 | 9,359,698.00 |
| 210302 | Түлш, халаалтын зардал | 64,093,780.00 | 84,022,652.00 |
| 210303 | Цэвэр, бохир усны зардал | 2,511,350.00 | 956,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 20,972,950.00 | 23,483,290.00 |
| 210502 | Хоол, хүнс | 20,972,950.00 | 23,483,290.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 3,999,700.00 | 9,447,450.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,999,700.00 | 9,447,450.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,207,100.00 | 8,105,622.34 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 338,600.00 | 875,500.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,868,500.00 | 7,230,122.34 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 16,974,565.50 | 15,577,383.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 14,589,865.50 | 13,363,683.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх | 2,384,700.00 | 2,213,700.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 15,081,870.56 | 20,225,012.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 15,078,129.00 | 20,225,012.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал | 15,078,129.00 | 20,225,012.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 3,741.56 | - |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,741.56 | - |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 23,488,340.50 | 179,957,282.66 |
| | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 11,687,000.00 | 39,719,457.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 11,687,000.00 | 39,719,457.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 11,687,000.00 | 39,719,457.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | - | 39,719,457.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 11,687,000.00 | - |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | (11,687,000.00) | (39,719,457.00) |
| | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | 11,801,340.50 | 140,237,825.66 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 6,722,822.95 | 18,524,163.45 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 18,524,163.45 | 158,761,989.11 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31* *//төгрөгөөр/*

Байгууллагын нэр: Цагаанхайрхан Ерөнхий боловролын сургууль

Тайлант хугацаа: 2024.12.31

### ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

| Д/Д | Үзүүлэлт | Засгийн газрын сан | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | 3Г-н хувь оролцооны дүн |
|---|---|---|---|---|---|
| 0 | ДАНС | 511 | 51300 | 51210+51220 | |
| 2 | 2023 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл | 278923016.50 | 274338023.00 | -228816050.23 | 324444989.27 |
| 3 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | |
| 4 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 278923016.50 | 274338023.00 | -228816050.23 | 324444989.27 |
| 5 | Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн | | | | |
| 6 | Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз | | | | |
| 7 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз | | | | |
| 8 | Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/ | | | -32136477.11 | -32136477.11 |
| 9 | 2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 278923016.50 | 542683236.00 | 52764822.02 | 874371074.52 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 10 | 2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 278923016.50 | 542683236.00 | 52764822.02 | 874371074.52 |
| 11 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | 89444854.00 | 89444854.00 |
| 12 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 278923016.50 | 542683236.00 | 142209676.02 | 963815928.52 |
| 13 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 0 | -89444854.00 | 0 | -89444854.00 |
| 14 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | |
| 15 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз | | | | |
| 16 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | |
| 17 | Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/ | 0 | 0 | 97765849.66 | 97765849.66 |
| 18 | 2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 278923016.50 | 453238382.00 | 239975525.68 | 972136924.18 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31* *(/төгрөгөөр/)*

Байгууллагын нэр: Цагаанхайрхан Ерөнхий боловролын сургууль

Тайлант хугацаа: 2024.12.31

### ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| Д/Д | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү дүн | Харьцуулалт |
|---|---|---|---|---|---|
| | | - | 18,524,163.45 | (18,524,163.45) | - |
| 2 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,202,884,600.00 | 1,034,691,098.34 | 168,193,501.66 | 86.02 |
| 21 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 1,202,884,600.00 | 994,971,641.34 | 207,912,958.66 | 82.72 |
| 210 | Бараа, үйлчилгээний зардал | 1,180,341,000.00 | 974,746,629.34 | 205,594,370.66 | 82.58 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 966,334,100.00 | 830,370,548.00 | 135,963,552.00 | 85.93 |
| 210101 | Үндсэн цалин | 690,695,300.00 | 489,986,277.00 | 200,709,023.00 | 70.94 |
| 210102 | Нэмэгдэл | 263,153,900.00 | 300,769,681.00 | (37,615,781.00) | 114.29 |
| 210104 | Урамшуулал | 12,484,900.00 | 39,614,590.00 | (27,129,690.00) | 317.30 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | - | - | - | - |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 120,792,000.00 | 103,180,452.00 | 17,611,548.00 | 85.42 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 82,138,400.00 | 74,567,200.00 | 7,571,200.00 | 90.78 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,663,300.00 | 8,409,300.00 | 1,254,000.00 | 87.02 |
| 210203 | ҮОМШӨ ний даатгал | 4,831,800.00 | 1,842,800.00 | 2,989,000.00 | 38.14 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,831,800.00 | 1,842,800.00 | 2,989,000.00 | 38.14 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 19,326,700.00 | 16,518,352.00 | 2,808,348.00 | 85.47 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2105 | Нормативт зардал | 23,895,200.00 | 23,483,290.00 | 411,910.00 | 98.28 |
| 210502 | Хоол, хүнс | 23,895,200.00 | 23,483,290.00 | 411,910.00 | 98.28 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 9,216,100.00 | 8,105,622.34 | 1,110,477.66 | 87.95 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,275,500.00 | 875,500.00 | 400,000.00 | 68.64 |
| 210806 | Мэдээллийн технологийн зардал | 7,940,600.00 | 7,230,122.34 | 710,477.66 | 91.05 |
| 2201 | Бараа үйлчилгээний бусад зардал | 60,103,600.00 | 9,606,717.00 | 50,496,883.00 | 15.98 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 57,226,500.00 | 7,393,017.00 | 49,833,483.00 | 12.92 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,877,100.00 | 2,213,700.00 | 663,400.00 | 76.94 |
| | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 22,543,600.00 | 20,225,012.00 | 2,318,588.00 | 89.72 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 22,543,600.00 | 20,225,012.00 | 2,318,588.00 | 89.72 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг | 22,543,600.00 | 20,225,012.00 | 2,318,588.00 | 89.72 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | - | 39,719,457.00 | (39,719,457.00) | - |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | - | 39,719,457.00 | (39,719,457.00) | - |
| 222001 | Тоног төхөөрөмж | - | 39,719,457.00 | (39,719,457.00) | - |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 1,184,360,900.00 | 1,180,899,590.00 | 3,461,310.00 | 99.71 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 1,177,697,400.00 | 1,177,697,400.00 | - | 100.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,177,697,400.00 | 1,177,697,400.00 | - | 100.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 6,663,500.00 | 3,202,190.00 | 3,461,310.00 | 48.06 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5,708,000.00 | 2,646,690.00 | 3,061,310.00 | 46.37 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажилагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 955,500.00 | 555,500.00 | 400,000.00 | 58.14 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 18,524,163.45 | (18,524,163.45) | - |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 158,761,989.11 | (158,761,989.11) | - |
| 6 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | - | - | - | - |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1.00 | 1.00 | - | - |
| 62 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 32.00 | 32.00 | - | 100.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | - | 100.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 20.00 | 20.00 | - | 100.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 11.00 | 11.00 | - | 100.00 |
| 620004 | Гэрээт ажилтан | - | - | - | - |
| 63 | СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/ | 1.00 | 1.00 | - | 100.00 |
| 630 | Ерөнхий боловсролын сургуульд суралцагчид | 1.00 | 1.00 | - | 100.00 |
| 630001 | Төрийн өмчит ЕБС | 1.00 | 1.00 | - | 100.00 |
| 64 | ЭМЧЛҮҮЛЭГСДИЙН ТОО | - | - | - | - |
| 65 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 32.00 | 32.00 | - | 100.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 650004 | СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч /ТҮБД/ | 21.00 | 21.00 | - | 100.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч /ТҮ/ | 11.00 | 11.00 | - | 100.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31* */төгрөгөөр/*

Байгууллагын нэр: Цагаанхайрхан Ерөнхий боловролын сургууль

Тайлант хугацаа: 2024.12.31

### НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

| Д/Д | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү дүн | Харьцуулалт |
|---|---|---|---|---|---|
| 2 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 103,785,800.00 | 103,785,800.00 | - | 100.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 103,785,800.00 | 103,785,800.00 | - | 100.00 |
| 210 | Бараа, үйлчилгээний зардал | 103,785,800.00 | 103,785,800.00 | - | 100.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 95,085,800.00 | 94,338,350.00 | 747,450.00 | 99.21 |
| 210301 | Гэрэл цахилгаан | 9,596,400.00 | 9,359,698.00 | 236,702.00 | 97.53 |
| 210302 | Түлш, халаалт | 83,792,600.00 | 84,022,652.00 | (230,052.00) | 100.27 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,696,800.00 | 956,000.00 | 740,800.00 | 56.34 |
| 2106 | Эд хогшил худалдан авах | 8,700,000.00 | 9,447,450.00 | (747,450.00) | 108.59 |
| 210604 | Урсгал засвар | 8,700,000.00 | 9,447,450.00 | (747,450.00) | 108.59 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 103,785,800.00 | 103,785,800.00 | - | 100.00 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 103,785,800.00 | 103,785,800.00 | - | 100.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 103,785,800.00 | 103,785,800.00 | - | 100.00 |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1.00 | 1.00 | - | - |
| 62 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 32.00 | 32.00 | - | 100.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | - | 100.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 20.00 | 20.00 | - | 100.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 11.00 | 11.00 | - | 100.00 |
| 63 | СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/ | 1.00 | 1.00 | - | 100.00 |
| 630 | Ерөнхий боловсролын сургуульд суралцагчид | 1.00 | 1.00 | - | 100.00 |
| 630001 | Төрийн өмчит ЕБС | 1.00 | 1.00 | - | 100.00 |
| 65 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 32.00 | 32.00 | - | 100.00 |
| 650004 | СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч /ТҮБД/ | 21.00 | 21.00 | - | 100.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч /ТҮ/ | 11.00 | 11.00 | - | 100.00 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Цагаанхайрхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн *үйл ажиллагааны чиглэл:*

- *Суурь боловсрол олгох үйлчилгээ*

*Цагаанхайрхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн зорилго:*

" Хамтын ажиллагаанд тулгуурлан хүүхэд бүрийг хөгжих тэгш боломжоор хангаж, эерэг хандлагыг эрхэмлэсэн сурлагын ахицтай суралцагч төлөвшүүлнэ " зорилгыг тавин ажиллаж байна.

2024 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 65 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг улирал тутам гаргаж, эрх бүхий албан тушаалтнаар дүгнүүлэн ажилласан байна. Төлөвлөгөөний гүйцэтгэлийн биелэлт 93 хувьтай байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Цагаанхайрхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаанд мөрддөг хууль:

1. Боловсролын ерөнхий хууль
2. Төрийн албаны тухай хууль
3. Төрийн хэмнэлтийн тухай хууль
4. Төсвийн тухай хууль
5. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
6. Нийгмийн даатгалын ерөнхий хууль
7. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
8. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
9. Хөдөлмөрийн тухай хууль
10. Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд орсон өөрчлөлт:

2024 оны 03 сарын 27-ны 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоосон, Боловсролын ерөнхий хууль 2024 оны 07-р сарын 07-нд батлагдсан. Засгийн газрын 2024 оны 08 сарын 28-ны 53 дугаар тогтоолоор "Хувьсах зардлын хэмжээ, итгэлцүүр" шинэчлэгдэн батлагдсан, Сангийн Сайдын 2024 оны 04 сарын 01-ний А/52 тушаалаар дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн баталсан

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ. Дотоод хяналтын багийг байгуулж, төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Мөн Санхүүгийн өдөр тутмын ажил гүйлгээнд Сургуулийн захирал, санхүүгийн албаны дарга, төсөв, төрийн сангийн мэргэжилтэн нар хяналтыг хийж байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цагаанхайрхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Цагаанхайрхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө өмнөх оноос 175,834.2 мянган төгрөгөөр буюу 20 хувиар өссөн байна.

***Хүснэгт 1.*** *Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Авлага | 0.00 | 0.00 | 0.00 |
| Бараа материал | 75,881.4 | 61,280.9 | 14,600.5 |
| Үндсэн хөрөнгө | 781,515.5 | 831,712.3 | 50,196.8 |
| **Нийт хөрөнгө** | **875,921.0** | **1,051,755.2** | **175,834.2** |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 874,371.1 | 972,136.9 | 97,765.8 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **875,921.0** | **1,051,755.2** | **175,834.2** |

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

**Тайланд онд:**

Бараа материалын эхний үлдэгдэл 75,881.4 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр 63,810.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 1,800.0 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүйгээр нэмэгдэж, 7,5247.1 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, 4,964.3 мянган төгрөгийн бараа материал акталж эцсийн үлдэгдэл 61,280.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 14,600.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгийн хувьд төсвийн хөрөнгөөр 119,337.7 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, хөрөнгө оруулалтаар 34,146.6 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүйгээр нэмэгдэж, 115,831.0 мянган төгрөгийн хөрөнгийг шийдвэрийн дагуу акталж, жилийн эцэст 1,224,274.3 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Тайлант оны элэгдлийн зардалд 100,794.8 мянган төгрөгийг тооцож бүртгэсэн байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 97,765.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй шууд холбоотой болно.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,184,360.9 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 103,785.8 мянган төгрөг,нийт зарлагыг 1,288,146.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 15 арга хэмжээг санхүүжүүлэхээр 103,785.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс,1,177,697.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 3,202.2 мянган төгрөгийг бусад үйл ажиллагааны орлогоос төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,144,447.6 мянган төгрөг буюу 89.1 хувьтай байна. Энэ нь цалин нийгмийн даатгалын шимтгэл зэрэг зардлыг 15,608.1 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

***Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл***

/мянган төгрөгөөр/

| Хөтөлбөрарга хэмжээ | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 71802/80109 | Тогтмол зардал | 103,785.8 | 103,785.8 | 0 0 | 100% |
| 71802/80226 | Байр ашиглалтын үйлчилгээ | 804.0 | 804.0 | 0 | 100% |
| 71802/80233 | Хүүхэд хамгаалал | 848.6 | 848.6 | 0 | 100% |
| 71802/80312 | Сургалт семинар | 600.1 | 600.1 | 0 | 100% |
| 71802/81605 | Мэдээлэл, сурталчилгааны зардал | 696.7 | 696.7 | 0 | 100% |
| 71802/81801 | Үдийн цай хөтөлбөр | 22,543.6 | 20,225.0 | 2,318.6 | 89.7% |
| 71802/81806 | Дотуур байрны үйлчилгээ | 134,017.3 | 121,773.6 | 12,243.7 | 90.9% |
| 71802/81816 | Хүүхдэд ээлтэй сургалтын орчин | 39,729.7 | 39,729.7 | 0 | 100% |
| 71802/81823 | Боловсролын байгууллагын багш ажилтны мэргэжил дээшлүүлэх | 2,090.0 | 612.0 | 1,478.0 | 29.3% |
| 71802/81827 | Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр | 5,668.5 | 5,668.5 | 0 | 100% |
| 71802/81834 | Боловсролын стандарт сургалтын орчин | 974,457.6 | 832,442.2 | 142,015.4 | 85.3% |
| 71802/81835 | Сургалтын хэвийн үйл ажиллагаа | 12,342.9 | 12,342.9 | 0 | 100% |
| 71802/81844 | Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн | 6,133.7 | 3,072.4 | 3,061.3 | 50.1% |
| 71802/81848 | Сурах бичгийн түрээс | 1,275.5 | 875.5 | 400.0 | 68.6% |
| 71802/81875 | Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх | 1,676.4 | 970.5 | 705.9 | 57.9% |
| **НИЙТ** | | **1,306,670.4** | **1,144,447.5** | **162,222.9** | **87.6%** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Орон нутгийн төсвөөс 103,785.8 мянган төгрөгийн орлого төвлөрүүлснээс гүйцэтгэлээр 103,785.8 мянган төгрөгийг гэрэл цахилгаан,түлш халаалт, цэвэр бохир ус,урсгал засварын зардалд зарцуулсан байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

Тайлант онд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй шууд худалдан авалтыг хийсэн байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Цагаанхайрхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг "Хаан соёмбо аудит ХХК"-ны гэрээт аудитор Б.Цэрэндэжид гүйцэтгэж, анхан шатны хяналтыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсувд хийж, чанарын хяналтыг аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Цагаанхайрхан сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 02 дугээр сарын 05-ны өдрийн 15 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг 1,220,373.4 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 18,305.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 13,729.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 31 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа, зөрчил илрээгүй байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2024 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 5 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

**4.5.1 Завсрын аудитын талаар**

Цагаанхайрхан сумын Ерөнхий боловролын сургуулийн  2024 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно..

**4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар акт,албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарах асуудал тодорхойлогдоогүй байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,453.0 мянган төгрөгийн алдаа илэрч  зөвлөмж өглөө.

***Залруулсан алдаа:***

Байхгүй

**Шийдвэрлэсэн байдал:** Байхгүй

**5.1 Төлбөрийн акт тогтоогоогүй**

**5.2 Албан шаардлага: өгөгдөөгүй**

**5.3 Зөвлөмж**

***Илэрсэн алдаа:*** Зардал хооронд 1,453.0 мянган төгрөгийг бараа материалд гүйлгэн зарцуулсан.

**Өгсөн зөвлөмж:** Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2.батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах; Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан

"Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"ыг, батлагдсан төсвийн дагуу эдийн засгийн ангилалаар зардал гаргах, хууль, журмыг мөрдөж ажиллах, хяналтыг хэрэгжүүлэх

***Илэрсэн алдаа:*** Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

***Өгсөн зөвлөмж:*** Дахин үнэлгээ хийх шалгуур хангасан хөрөнгөнд үнэлгээ хийж бүртгэлд тусгах, цаашид ашиглах боломжгүй хөрөнгүүдийг холбогдох газрын зөвшөөрлийн дагуу данснаас хасах арга хэмжээ авч, үндсэн хөрөнгийн бүртгэлийг цэгцлэх;

Энэхүү зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг түвшингөөс бага байгаа тул "**Өөрчлөлтгүй**" дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

*/мянган төгрөгөөр/*

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үнэлгээ | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Зардлыг эдийн засгийн ангиллаар зарцуулаагүй байна. | 1 | 1453.0 | | | | | 1 | 1453.0 | | | | |
| Анхны өртгөө элэгдлээрээ нөхсөн 0 үлдэгдэлтэй байгаа 188 нэр төрлийн 113,181,084.39 төгрөгийн хөрөнгийг дахин үнэлж ашиглалтын хугацааг сунгах | 1 | | | | | | 1 | | | | | |
| **Дүн** | | **1453.0** | | | | | | **1453.0** | | | | |

**АУДИТЫН ТАЙЛАНГ:**

**ХЯНАСАН:**

АХЛАХ АУДИТОР Ц.ОЮУНСУВД

АУДИТЫН МЕНЕЖЕР: Х.БОЛДБААТАР

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-УНДРАА

Огноо: 2025-02-07

**БОЛОВСРУУЛСАН:**

"ХААН СОЁМО АУДИТ" ХХК ГЭРЭЭТ АУДИТОР Б.ЦЭРЭНДЭЖИД

Огноо: 2025-02-07